ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН
ТАНАА

Үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмж

"Төмсний үр худалдан авах" ХХААХҮЯ/202401022075 тендерийг 02 дугаар сарын 29-ний өдөр цахимаар зарласан.

Тус зарлалын хүрээнд тендер сонирхосон этгээд болох "Элит үр" ХХК-ийн төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ирүүлсэн тодруулгыг нягтлан үзэж үнэлгээний хороогоор хэлэлцүүлэн техникийн тодорхойлтод заагдсан репродукцийн стандарт 2-ыг харьцуулахад зэх зээлийн үнээс хэт өндөр байгаа тул MNS-0886:2006 стандартыг элит үрийн MNS-3223:2006 стандарт болгон тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж нээх хугацааг 5 хоногоор сунгах зөвлөмжийг хүргүүлж байна.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА, ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ДАРГА Д.ЕСӨН-ЭРДЭНЭ

**БАТЛАВ:**
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЖАМБАЛЦЭРЭН

**Техникийн тодорхойлолтын шаардлага үзүүлэлт**
**Төмсний үр 170 тонноос багагүй**
**Төсөв 300,000,000 /Гурван зуун сая/ төгрөг**

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

| № | Үзүүлэлт | Нийлүүлэгчийн тодорхойлолт |
|---|---|---|
| 1. | Ерөнхий үзүүлэлтүүд<br>- Таримлын нэр:<br>- Сортын нэр:<br>- Гарал үүсэл:<br>- Үйлдвэрлэсэн он /2023 он / | |
| 2. | - Таримлын сорт: Монгол улсад нутагшсан болон ирээдүйтэй сортын үр байна.<br>- Үрийн чанарын шаардлага: Улсын үрийн MNS-3223:2006 стандартын шаардлагыг хангасан байна. | |
| | Элит үр | |
| 3 | 1. Гадаад байдал: Бүтэн, эрүүл, хуурай, болц гүйцсэн,цэвэр, уг сортын хэлбэр дүрс, шинж чанарыг бүрэн хадгалсан байна.<br>- Гонзгой булцуутай сортын голч 35-55 мм<br>- Бөөрөнхий булцуутай сортын голч 45-65 мм<br>- булцууны жин- гр 40-100<br>2. Төмсний өвчин<br>- Фитофтор 0,5<br>- нойтон илжрэл 0<br>- Хуурай илжрэл 0,5<br>- Цагирган илжрэл 0<br>- Энгийн цахлай гадаргуугийн 3/1 ээс дээш 1.0<br>- Хар цахлай 1,0<br>- Нунтаг цахлай 1,0<br>- Төмөрлөг толбожилт махлаг эдийн харлалт 2,0 | |
| 4 | - Үр тус бүрийг Савлагаа 10 кг-аар уутанд савлаж, нийлүүлэгчийн гарал үүсэл, компаний хаяг, утасны дугаарыг заавал тодоор бичиж наасан байна.<br>- Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт: Нийлүүлэгч барааг Улаанбаатар хотод зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслэлээр тээвэрлэн авчирч зориулалтын хөргүүртэй агуулахад хадгалж Захиалагчид хүлээлгэн өгөх ба Захиалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийн дагуу эцсийн хүлээн авагчид барааг хүлээлгэн өгч дуусгана. | |

## *Шалгалт, туршилт*

1. *Үрийг хүлээлгэн өгөх үед шалгаж хүлээн авна. Шалгах үед зөөлөрсөн, няцарсан, ялзарсан, өвчилсөн байвал нийлүүлэгч өөрийн зардлаар ялгаж цэвэрлэж зөрүү жинг тоо хэмжээгээр акт үйлдэж хохирлыг үрээр болон тендерт нийлүүлэх санал болгосон мөнгөн дүнгийн зөрүүгээр хохирлыг барагдуулна.*

2. *Нийлүүлэхээр санал болгож буй үрийн дээжийг Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторын байгууллагад шинжлүүлж чанар, стандартын шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээний дүн, түүнд үндэслэсэн таримал ургамал үр, хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж ирүүлсэн байна.*

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Монгол улсын байгаль, цаг уур, хөрсний шинж чанар, онцлогт тохирч нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан дүйцэх төмсний үр байх ба эрт болон дунд эртийн сортын нийлүүлнэ.
2. Нийлүүлэх төмсний үр нь MNS-3223:2006 стандартын шаардлагыг хангасан байна.

3.Тендерт оролцогчийн санал болгосон үрийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, зураг, сертификат г.м/ ирүүлнэ.

a. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанарын шаардлага хангаж байгааг нотлох а) барааны гарал үүсэл, б) чанар в) ургамал хорио цээрийн гэрчилгээний хуулбарыг албан ёсны орчуулгын товчоогоор орчуулуулж ирүүлнэ.
b. Гадаад орноос болон дотоодын нийлүүлэгдэх үрийн үйлдвэрлэгч нь Тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон үр үржүүлэх эрх бүхий хуулийн этгээд байх ба энэ тухай баримт, нотолгоо ирүүлнэ. Албан ёсны орчуулгатай байна.
c. Нийлүүлэх төмсний үрийн талбайд хянан баталгаа хийгдсэн байна. Энэ тухай баримт нотолгоо ирүүлнэ.
d. Тарих үрийн технологи, зөвлөмж, үйлдвэрлэгчийн танилцуулга